


МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН УУРХАЙН АВРАХ АЖИЛЛАГААНЫ
ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛИЙН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

MNS 6711 : 2018



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР ХОТ
2018 ОН

Өмнөх үг

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үндэсний стандартчиллын бодлогыг хэрэгжүүлэх ажил эрхэлдэг.

Стандартын төсөл боловсруулах ажлыг салбарын стандартчиллын Техникийн хороо (ТХ), Дэд хороо (ДХ) эрхлэн гүйцэтгэдэг бөгөөд Техникийн хорооны хурлаар хэлэлцэж 75%-иас доошгүй дэмжиж зөвшилцсөн төслийг Стандартчиллын үндэсний зөвлөл (СҮЗ)-өөр хэлэлцэн, тогтоолоор баталснаар хүчин төгөлдөр болно.

Энэхүү стандартыг ШУТИС-ийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Хөнгөн үйлдвэрлэлийн технологи, инженерчлэлийн салбарын ахлах багш, доктор Д.Буяндэлгэр, багш Б.Батдулам, Р.Юмжирмаа, профессор Л.Удвал, "Аюулгүй хөдөлмөрийн үндэс" НҮТББ-ийн зөвлөх, доктор Д.Энхжаргал, Гамшиг судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан А.Ариунбилэг нар боловсруулж, СХЗГ-ын мэргэжилтэн Ч.Пүрэвдулам "Монгол улсын стандартчиллын тогтоолын 2-р хэсэг: "Стандартын бүтэц ба боловсруулах дүрэм MNS 1-2:2006" стандартад нийцүүлэн засварлав.

Уг стандартыг Текстилын техникийн хороогоор хэлэлцэн дэмжсэн болно.

Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А
Улаанбаатар 13348, ШХ-48
Утас: 266754, 263860,
Факс: (976-11) 458032
E-mail: standardinform@masm.gov.mn
Вэб сайт: www.estandart.mn,
www.masm.gov.mn

© СХЗГ, 2018

"Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай" Монгол улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага)-т байна.

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 61.020, 13.340.10

Онцгой байдлын байгууллагын уурхайн аврах ажиллагааны хувцас, хэрэглэлийн техникийн шаардлага

Mine rescue immersion suits and components /equipments/. Technical requirements

MNS 6711 : 2018

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн мөрдөнө.

1 Зорилго

Энэхүү стандарт нь уурхайн аврах ажиллагаанд оролцох алба хаагчын хамгаалалтын хувцас болон хэрэглэлийг сонгох, түүнийг хэрэглэх, арчлах, хадгалах системийг бий болгох зорилготой.

2 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь уурхайн аврах ажиллагаанд ашиглах хувцас, хэрэглэлийн ангилал, тавигдах шаардлага, бэлэн бүтээгдэхүүний чанарыг шалгахад зориулагдана.

3 Норматив ишлэл

Энэ стандартыг боловсруулахад дараах нормативуудаас иш татсан бөгөөд эдгээрт нэмэлт, өөрчлөлт орвол энэ стандартад нэгэн адил хамаарна. Үүнд:

ISO 15027-1:2012	Аврах ажиллагааны хувцас. Аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байнгын хувцас
ISO 13688:2016	Хамгаалалтын хувцас- Ерөнхий шаардлага
ISO 3635:1981	Хувцасны өмсгөл хэмжээ, Биеийн хэмжээний тодорхойлолт, хэмжих арга
ISO 8559:1989	Хувцасны зохион бүтээлт болон хэмжил зүйн судалгаа, Биеийн хэмжээ
ISO 3758	Нэхмэл – Хувцас арчилгааны шошго дээрх тэмдэг, тэмдэглэгээ
ISO /TR 11079:1993	Хүйтэн орчныг үнэлэх- хувцасны дулаан тусгаарлалтыг тодорхойлох
MNS 4968:2000	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага
MNS 6306:2012	Тусгай зориулалтын дулаан хувцас, Ерөнхий шаардлага
MNS 6231:2011	Тусгай зориулалтын ажлын хувцас, Ерөнхий шаардлага
MNS 5621:2006	Толгой хамгаалах хэрэгсэл. Дуулга
MS 5624:2006	Толгой хамгаалах хэрэгсэл. Нүүррэвч
MNS ISO 4417:2012	Малгайны өмсгөл хэмжээний тэмдэглэгээ

MNS 5622:2011	Хамгаалалтын бээлий. Ерөнхий шаардлага
MNS 5623:2006	Хөлний хамгаалалт. Ажлын тусгай гутал
MNS4252:1995	Насанд хүрэгсдийн биеийн хэв шинжит галбир, ангилал хэмжээ
MNS ISO 4916:2011	Оёдлын нэр төрөл-ангилал ба нэр томъёо
MNS ISO 4915:2012	Хатгацын төрөл - Ангилал ба нэр томъёо

4 Нэр томъёо, тодорхойлолт

Энэхүү стандартад дараах нэр томъёо, тодорхойлолтууд ашиглагдсан болно.

4.1

Уурхайн аврах ажиллагааны хувцас

газрын гүнээс аврах ажиллагааны үед өмсөхөд зориулагдсан хувцас,

4.2

Уурхайн аврах ажиллагааны хүйтний улирлын хувцас

гадна орчны температур 0 °C –ээс доош үед хэрэглэгдэх гадуур хувцас,

4.3

Уурхайн аврах ажиллагааны дулааны улирлын хувцас

улирал харгалзахгүй аврах ажиллагааны үед өмсөх хувцас

4.4

Дуулга

газрын гүнээс аврах ажиллагааны үед өмсөхөд зориулагдсан толгой хамгаалах хэрэглэл

4.5

Бээлий

газрын гүнээс аврах ажиллагааны үед өмсөхөд зориулагдсан гар хамгаалах хэрэглэл

5 Ангилал

5.1 Онцгой байдлын байгууллагын уурхайн аврах ажиллагааны хувцас, хэрэглэлийг нэр төрлөөр нь дараах байдлаар ангилна. Үүнд:

- Уурхайн аврах ажиллагааны хүйтний улирлын хувцас, хэрэглэл
- Уурхайн аврах ажиллагааны дулааны улирлын хувцас, хэрэглэл

5.2 Дээрх нэр төрлийн хувцсыг иж бүрдлээр нь дараах байдлаар ангилна. Үүнд:

- Уурхайн аврах ажиллагааны хүйтний улирлын хувцас, хэрэглэл нь:
 - Дулаалгатай гадуур хүрэм
 - Дулаалгатай гадуур өмд
 - Хамгаалалтын дуулга
 - Бээлий
 - Гутал

Б. Уурхайн аврах ажиллагааны дулааны улирлын хувцас, хэрэглэл нь:

- Хүрэм

- Өмд
- Дуулга малгай
- Бээлий
- Гутал

6 Техникийн шаардлага

Уурхайн аврах ажиллагааны аврагчдын ажлын хувцсыг энэхүү стандартад дурьдсан ерөнхий шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэнэ.

6.1 Гадаад байдалд тавигдах шаардлага

- Хувцасны загварын шийдэл нь аврагчийн ажлын онцлогт тохирно.
- Хувцас нь аюулгүй байдлыг хангаж ялгарч харагдах тод өнгөтэй байна.
- Хувцасны загварын боловсруулалт нь зохих технологийн болон чанарын шаардлага хангана.
- Хувцасны таних тэмдэг, тэмдэглэгээ нь өнгө үзэмжтэй, тогтсон хэмжээ, байрлалтай байна.

6.2 Өмсгөл хэмжээ

- Хувцасны өмсгөл хэмжээс нь мөрний хэсгийн хувцсанд биеийн өндөр ба цээжний бүслүүрийн хэмжээ, бүсэлхийн хэсгийн хувцсанд бүсэлхийн бүслүүр ба алхамын уртын хэмжээгээр илэрхийлэгдэнэ.
- Хувцасны өмсгөл хэмжээ нь MNS 3631 истандартын эрэгтэй насанд хүрэгчдийн хэв шинжит галбируудын ангиллын биеийн үндсэн хэмжээсүүдэд тохирно.
- Хувцасны сулын хэмжээ цээжний бүслүүрт дулааны улирлын хувцсанд 12 см-аас багагүй, хүйтний улирлын хувцсанд 16 см-аас багагүй байна.
- Аврах ажиллагааны хувцсыг зөвхөн зориулалтын дагуу хэрэглэнэ.
- Бэлэн бүтээгдэхүүний үндсэн хэмжээсүүдийг хэмжих байрлалууд, тэдгээрийн утгууд, хазайлтын хязгаарыг хувцасны техникийн баримт бичигт тусгана.
- Хувцас нь байгууллагын тогтоосон хэв загвартай байна.

6.3 Эргономик /биед эвтэйхэн байх/-ийн шаардлагууд

- Хувцасны хийц нь аврах ажиллагааны үеийн хөдөлгөөний онцлогт тохирсон, биед эвтэй, чөлөөтэй хөдлөх боломжийг хангасан байна.
- Аврах ажиллагааны хувцас нь өмсөхөд хялбар байна.
- Аврагчид шаардлагатай үед дохионы гал, аврах хэрэгслүүдийг бэхлэх бэхлэвч, бусад элементүүдийг оновчтой байрлал, хэмжээтэй байхаар хувцсан дээр хийнэ.
- Хувцас нь байршил тогтоогч GPS хийх зориулалттай халаастай байна.
- Шаардлагатай үед аварчийг өргөхөд зориулсан дэгээг хувцасны хийцэд тусгасан байна.
- Хувцсыг хүний биеийн хэмжээнд тааруулах ихэсгэгч, багасгагчтай хийнэ.
- Хүйтний улирлын хувцас нь аврах ажиллагаа явуулахад хөнгөн, дулаан байна.

6.4 Эдэлгээний шаардлага

- Хувцас нь бөх бат, эдэлгээний хугацаанд хамгаалах чадвараа найдвартай хадгалах, хадгалалт элэгдэлтэнд тэсвэртэй, засварлах боломжтой байна.
- Гарын тохой ба хөлийн өвдөгний хэсэгт хувцасны эдэлгээг уртасгах зорилгоор давхарлага хийнэ.

6.5 Хувцасны материалд тавих шаардлага

- Уурхайн аврах ажиллагааны хувцасны гадар материал нь гадны механик үйлчлэлд тэсвэртэй, салхи нэвтрүүлэлт нь зохих түвшинд байх, гаднаас ус чийг нэвтрүүлэхгүй, хөлддөггүй байна.
- Хувцасны гадар материалын шинж чанарын нийтлэг үзүүлэлт нь 1-р хүснэгтэд заасан шаардлагыг хангана.

Гадрын материалын шинж чанарын нийтлэг үзүүлэлт

1 дүгээр хүснэгт

д/д	Үзүүлэлтийн нэр		Хэмжих нэгж	Зөвшөөрөгдөх хэмжээ
1	Үндсэн өнгө- хар хөх		Пантон код	Pantone 19-4023 TPX(Blue Nights)
	Хосолсон өнгө- улбар шар			Pantone 17-1464 TPX(Red Orange)
2	Гадаргуугийн нягт		г/м ² , багагүй	200
3	Ширхэгтийн бүрэлдэхүүн	Байгалийн ширхэгт	%, багагүй	30
		Хиймэл ширхэгт		70-аас ихгүй
4	Зузаан		мм, ихгүй	0.6
5	Тасралтын хүч	Суурь утас	Кг/хүч, багагүй	780
		Хөндлөн утас		650
6	Урагдалтын хүч	Суурь утас	Кг/хүч, багагүй	51
		Хөндлөн утас		36
7	Будгийн тогтвор	Хуурай цэвэрлэгээнд	Балл, багагүй	3
		Угаалтанд		
		Нарны гэрэлд		
8	Агаар нэвтрүүлэлт		дм ³ /м ² с	7-40
9	Даавууны агшилт, суналт (удаагийн угаалтын дараа)		%	±2.0
10	Формальдегидын агууламж,		мг/кг	70-75

Хүйтний улирлын дулаан хувцсанд түгээмэл хэрэглэгдэж буй синтетик болон малын гаралтай ноосон ширхэгтэн дулаалгын материалын шинж чанарын нийтлэг үзүүлэлтэд (2,3-р хүснэгт) тохирсон байна.

Дулаалгын материалд тавигдах шаардлага

2 дүгээр хүснэгт

д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Зөвшөөрөгдөх хэмжээ
1	Дулаалгын материалын нэвчилт (өнгө болон дотрын материалаас)	150см ² талбайд ширхэг, ихгүй	2
2	Чийг шингээх чадвар	%, багагүй	3

Нийлэг дулаалгын материалын шинж чанарын нийтлэг үзүүлэлт

3 дугаар хүснэгт

д/д	Үзүүлэлтийн нэр		Хэмжих нэгж	Зөвшөөрөгдөх хэмжээ
1	Гадаргуугийн нягт		гр/м ²	80-200
2	Зузаан		Мм, багагүй	20
3	Жин	Ар энгэрт	Гр/ м ²	0,28
		Ханцуй өмдний бүрдэл хэсэгт		0,175
		Халаасны таг, цахилгааны даралт, зах бусад хэсэгт		0,07
4	Жингийн жигд бус байдал		%	±10
5	Агшилтын өөрчлөлт Суурь утас Хөндлөн утас		%	±2.5

Тайлбар: * нь жингийн нэгжийг грамм руу шилжүүлэхдээ 0.035-аар үржүүлнэ.

Ноосон ширхэгтэн дулаалгын материалын шинж чанарын нийтлэг үзүүлэлт

4 дүгээр хүснэгт

д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Зөвшөөрөгдөх хэмжээ
1	Гадаргуугийн жин	гр/м ²	200-240
2	Зузаан	мм	12-24

6.6 Дотрын материалд тавих шаардлага

Хүйтний улирлын дулаан хувцасны дотрын материалын шинж чанарын нийтлэг үзүүлэлт нь 5-р хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна.

Дотрын материалын шинж чанарын нийтлэг үзүүлэлт

5 дугаар хүснэгт

д/д	Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Зөвшөөрөгдөх хэмжээ
1	Гадаргуугийн жин	гр/м ² , багагүй	110
2	Хиймэл ширхэгтийн агууламж	%	80-100
3	Тасралтын ачаалал	Суурь утасны дагуу	20
		Хөндлөн утасны дагуу	16
4	Чийг шингээх чадвар	%	10-аас багагүй
5	Угаалгын дараах агшилт	Суурь утасны дагуу	±2.0
		Хөндлөн утасны дагуу	±2.0
6	Будгийн тогтвор: угаалга, хөлс, хуурай үрэлт, хими цэвэрлэгээ	Балл, дээш	3
7	Формальдегидын агууламж,	мг/кг	70-75

- Дулаалгатай хувцсанд (зузаан болон давхаргын тоогоор) шаардлагатай дулаан хадгалах чадварыг хангаж чадах ямар ч төрлийн дулаалгын материал ашиглаж болно.
- Хувцасны туслах материал /товч, цахилгаан товч гэх мэт/ нь бөх бат хэрэглэхэд хялбар шийдлийг бүрэн хангасан байна.
- Цахилгаан товчлоостой байна.

7 Хувцаснаас бусад бүрдэлд тавигдах шаардлага

7.1 Гуталд тавигдах шаардлага

Хурц ирмэг үзүүртэй биет юмстай харьцах, тослог гадаргуутай харьцах, халуун нөхцөл, цахилгаан гүйдэл, цахилгаан цэнэгтэй харьцах, химийн хуурай нунтаг болон шингэн хортой бодистой харьцах зэрэг онцгой тохиолдолд өмсөх гутал

Хагас түрийтэй үдээсгүй байна. Түрийний өндрийг хэрэглэгчдийн захиалгаар уртасгаж эсвэл богиносгож болно.

Гутлын өмсгөл хэмжээ 6-р хүснэгтэд заасантай тохирох ёстой.

Гутлын өмсгөл хэмжээ

6 дугаар хүснэгт

Өмсгөл хэмжээний систем	Өмсгөл хэмжээ													
	240	245	250	255	260	265	270	275	280	285	290	295	300	305
Метрийн, мм														
Метрийн, см	25	25 1/2	26	26 1/2	27	27 1/2	28	28 1/2	29	29 1/2	30	30 1/2	31	31 1/2

Гутал нь EN ISO20345:2004 стандартад заасан S1, S2 ангилалын шаардлага хангасан байна (7-р хүснэгт).

Онцгой нөхцөлд өмсөх гуталд тавигдах шаардлага

7 дугаар хүснэгт

Ангилал	Материалын нэр төрөл	Шаардлага	Таних тэмдэг
S1	Арьс ширэн	Уян хатан байх Халтирахаас хамгаалах Механик биетээс хамгаалах (200Дж) Химийн бодисоос хамгаалах Цахилгаанаас хамгаалах	
S2	Арьс ширэн	S1+ Ус чийгээс хамгаалах	

7.2 Бээлийнд тавигдах шаардлага

- Гадны үйлчлэлээс гарыг хамгаалах хувийн хэрэглэл (тохой эсвэл мөр хүртэл янз бүрийн урттай байж болно).
- Уурхайн аврах ажиллагааны ажилтны ажлын бээлийг хүйтний ба дулааны улирлын гэж үндсэн 2 ангилалд хуваана.
- Хүйтний улирлын бээлий нь нэг хуруутай дулаалгатай, арьсан давхарлагатай таван хуруутай бээлий
- Дулааны улирлын бээлий нь нэг хуруутай дулаалгагүй бээлий, арьсан давхарлагатай таван хуруутай бээлий, сүлжмэл бээлий түрхлэгтэй, түрхлэггүй /полимер цэгэн түрхлэгтэй, PVC түрхлэгтэй байна.
- Бээлийний материал нь гарт харшил үүсгэх бодис агуулаагүй байна.
- Бээлийний гадар материалын нийтлэг үзүүлэлт нь 8-р хүснэгтэд заасан шаардлагад нийцсэн байна.

Бээлийний гадрын материалын нийтлэг үзүүлэлт

8 дугаар хүснэгт

Үзүүлэлтийн нэр	Механик үйлчлэл				Халуун үйлчлэл				Хоргүй тоос		
	үрэлт	хатгалт	зүсэлт	чичиргээ	Цацрагийн дулаан	Хайлмаг төмөрлөгийн дөл, шүрдэс, оч	40°C-аас 100°C хүртэл гадаргуутай халсан	100°C-аас 400°C хүртэл гадаргуутай халсан	Хүйтний үйлчлэл	жижиг ширхэгтэй тоос	том ширхэгтэй тоос
1. Гадаргуугийн нягт, г/м ² , ихгүй	650	650	650	470	800	730	800	800	800	410	460
2. Тасралтын ачаалал, Н, багагүй суурь утасны хөндлөн утасны	600 400	670 450	1000 600	600 600	530 470	1200 850	520 420	490 410	520 380	1200 630	440 310
3. Үрэлт даах чадвар, мөчлөг, багагүй	500	500	500	500	500	500	500	500	500	500	500
4. Ширүүн чанар, сН, ихгүй	27	27	27	27	16	27	27	16	16	16	16
5. Сэмрэлт, Н, багагүй	40	40	40	40	40	40*	40	40*	40*	40	40
6. Нойтон боловсруулалтын дараах шугаман хэмжээний өөрчлөлт, %, ихгүй	5	5	5	5	5	5	5	5	5	5	5
7. Чийг шингээлт, %, багагүй	5	5	5	5	5	5	5	5	5	5	5
8. Хатгалт даах чадвар, Н, багагүй	-	13	-	-	-	-	-	-	-	-	-
9. Зүсэлт эсэргүүцэх чадвар, Н/мм, багагүй	-	-	2	-	-	-	-	-	-	-	-
10. Гал тэсвэрлэлт, с	-	-	-	-	30	30	-	-	-	-	-

*ноосон ба хагас ноосон даавуунаас бусад материал

Бээлийний зориулалттай арьсны чанарын үзүүлэлт

9 дүгээр хүснэгт

Үзүүлэлтийн нэр	Механик үйлчлэлээс (хатгалт, зүсэлт, үрэлт)	Халууны үйлчлэлээс (дөл, оч, төмөрлөгийн хайлмаг, шүрдэс); 40°C-аас 100°C хүртэл халсан гадаргуутай хүрэлцэх
1. Тасралтын ачаалал, Н, багагүй	130,0	130,0
1. Хатгалт даах чадвар, Н, багагүй	58,0	-
2. Үрэлт даах чадвар, мөчлөг, багагүй	7000,0	7000,0
3. Зүсэлт эсэргүүцэх чадвар, Н/мм, багагүй	8,0	-
4. Жин 1м ² /г, ихгүй	530,0	530,0
5. Ширүүн чанар, сН, ихгүй	10,0	10,0
6. Урагдалтын ачаалал, Н, багагүй	3,4	3,4
7. Шаталт даах чадвар, с, багагүй	-	60,0

Брезентэн бээлийний материалын үзүүлэлт

10 дүгээр хүснэгт

Үзүүлэлтийн нэр	Норм
1. Тасралтын ачаалал, даН (кгс), багагүй Суурь утасны Хөндлөн утасны	90 (92) 65 (67)
2. Ширүүн чанар, сН, ихгүй	27
3. Тасралтын үеийн бөх байдал, Н, багагүй	140,0
4. Чийг шингээлт, %, багагүй	7,0
5. Сэмрэлт, Н, багагүй	40,0
6. Хатгалт даах чадвар, Н, багагүй	3,0
7. Агаар нэвтрүүлэлт, дм ³ /м ² , с, багагүй	5,0
8. Зүсэлтийн эсэргүүцэл, Н/мм, багагүй	2,0

Сүлжмэл бээлийний үзүүлэлт

11 дүгээр хүснэгт

Үзүүлэлтийн нэр	Норм
1. Гадаргуугийн нягт, г/м ² , ихгүй	300
2. 5 см дахь босоо эгнээний нягт, гогцооны тоо	25,0
3. Тасралтын үеийн бөх байдал, Н, багагүй	140,0
4. Чийг шингээлт, %, багагүй	7,0
5. Ширүүн чанар, сН, ихгүй	1,0
6. Агаар нэвтрүүлэлт, дм ³ /м ² , с, багагүй	200,0
7. Зүсэлтийн эсэргүүцэл, Н/мм, багагүй	2,0

7.3 Дуулганд тавигдах шаардлага

Толгой хамгаалах хэрэгслийн MNS 5621:2006 стандартад нийцсэн байна.

- Дуулга нь эрх бүхий байгууллагаар шалгагдаж баталгаажуулсан гэрчилгээтэй байна.
- Толгойн хамгаалах дуулга нь толгой дээр гадны биет унахад толгойг хамгаалахаас гадна, хөлсийг зайлуулах агааржуулагчтай байна.
- Сонсгол хамгаалах хэрэгсэлтэй дуулга нь 85 дБ-с дээш шуугианыг үйлдвэрийн бүх давтамжинд найдвартай бууруулж, чихэвч нь хүний чихэнд сөрөг нөлөөгүй байна.
- Нүд хамгаалах хэрэгсэлтэй дуулга нь хөдөлмөрийн нөхцөлөөс шалтгаалан тунгалаг (салхины хүчин нь 12-190м/с) гэрлийн бууралт (0-11 DIN бууруулахтай) ба өнгө үзэмжтэй, харшил өгөхгүй, нүдийг гадны биетээс найдвартай хамгаалсан байна.

8 Бүтээгдэхүүнд тавигдах шаардлагууд**8.1 Хувцасны оёдолд тавих шаардлага:**

- а. Хувцасны бүрдэл хэсгийг оёх хатгац, оёдлын төрөл MNS ISO 4916:2011, MNS ISO 4915:2012 стандартад нийцсэн байна.
- б. Хувцасны нэгтгэх бүх оёдол 1.0см-т 3.5-4 ширхэг хатгацтай байна.
- в. Ил оёдол нь тэгш, алгасаагүй, шигээгүй, тунараагүй байна.
- г. Нэгтгэх оёдлын тасралтын ачаалал 250 Н-аас багагүй байна.
- д. Хувцасны суга, өмдний суудлын оёдол, халаас, мөрний оёдол гэх мэт ачаалалд их өртдөг зангилаа хэсгүүдийг нэгтгэж оёхоос гадна ил оёдол нэмэлтээр хийсэн байна.
- е. Хос оёдол хоорондын зай 5 мм, оёдлын бүх уртад ижил зайд мурийлтгүй байна.

8.2 Оёдлын бөхөлгөө хийхэд тавих шаардлага

Оёдол бүрийн төгсгөлд зайлшгүй бөхөлгөө хийнэ. Түүнд дараах шаардлагууд тавигдана. Үүнд:

- а. Ердийн хатгац (MNS ISO 4915:2012) бүхий оёдлын төгсгөлд буцах чиглэлээр 0.7-1.0 см урттай бөхөлгөө хийнэ.
- б. Гинжин хатгац бүхий оёдлын бөхөлгөөг 1.0 см-д ноогдох хатгацын тоог 10 ширхэг хүртэл нэмэгдүүлэх байдлаар эсвэл оёдлын утсыг 0.5-0.7 см урттайгаар үлдээнэ.
- в. Битүү оёдлын эхлэл төгсгөлийн бөхөлгөөг оёдлын мөрөн дээр 1.0-2.0см урттай давхарлаж хийнэ.
- г. Хувцасны халаасны таг, хагалбар болон оёдолд орсон хагалаа халаасны эхлэл болон төгсгөл, ил халаасны амсар, далд товчлоос, цахилгаантай болон товчтой өмдний халаа, бүсний сойлт, түдүүлд тусгай зориулалтын машинаар бөхөлгөө хийнэ.

8.3 Товч, цахилгаан товч хадах, товчны нүх гаргахад тавих шаардлага

- а. Товчны нүхний уртын хэмжээ уг бүтээгдэхүүнд хадагдах товчны диаметрээс 0.2-0.5 см илүү байна.
- б. Товч хадах, товчны нүх гаргахдаа хоёроос доошгүй давхарласан материал дээр хийнэ.

- в. Товчны нүхийг заавал тусгай зориулалтын машинаар гаргаж цоолж, төгсгөлийг бөхөлсөн байна.
- г. Товчийг түүнтэй ижил өнгийн утсаар хадна.
- д. Товчлоосны зориулалттай дэгээ, гогцоо, товчийг машинаар эсвэл гараар хадна. Машинаар хадахдаа товчны нүх бүрийг, дэгээг 2 газарт (нүх бүрт), гогцоог 3 газарт (нүх бүрт болон түүний өмнө) 12-оос доошгүй хатгацаар оёно.
- ё. Дэгээ болон товчийг гараар хадахдаа 10,20,30 номерийн хөвөн даавуун утсаар, эсвэл 44 лх-1, 65 лх армир утсаар бөхөлж оёно. Товчлогдох нүхтэй товчийг суурьтайгаар, сэнжтэй товчийг суурь нэмж гаргахгүйгээр хадна.

9 Бэлэн бүтээгдэхүүнд тавигдах шаардлага**9.1 Хувцасны шошгонд тавих шаардлага**

Хувцасны шошго нь түүний ашиглалтын нөхцлийг илэрхийлэх бөгөөд дараах шаардлагуудыг хангана.

А. Шошго нь дараах мэдээллийг агуулна. Үүнд:

- Үйлдвэрлэгч байгууллагын нэр
- Хувцасны нэр төрөл
- Хувцасны хэмжээ (чац, өмсгөл хэмжээ, дүүргэвч)
- Хувцасны давхаргуудын материалын ширхэгтийн холио
- Шалгасан огноо
- Зурган тайлбар
- Арчилгааны заавар бүхий тэмдгүүд (ISO 3758)

б. Хүрэмний дотрын хажуу оёдолд, өмдний бүсний хэсгийн дотор

талд

шошгыг хадна.

В. Шошго нь сайн харагдах, уншигдах боломжтой байна.

Г. Шошго нь тухайн хувцасны угаалга, цэвэрлэгээг (угаалга, цэвэрлэгээний

давтамжийн тоонд тохирох) тэсвэрлэхээр бат бөх байна.

9.2 Хувцас савлах, тэсвэрлэх, хадгалахад тавих шаардлага
Хувцас савлах

а. Хүрэм өмдний хослол бүрийг тусгай зориулалтын гялгар уутанд савлан хэд хэдээр нь багцалж хайрцаглана.

б. Үйлдвэрлэгч нь барааны дагалдах хуудсыг хоёр хувь бичиж, нэг хувийг хайрцагны дотор талд хийж, хоёр дахь хуудсыг хайрцагны гадна талд наана. Дагалдах хуудсанд бүтээгдэхүүний нэр төрөл, тоо ширхэг, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, огноог бичсэн байна.

в. Хайрцагны хажуу талд ус, чийгнээс хамгаалахыг анхааруулсан таних тэмдгийг тод өнгөөр тэмдэглэсэн байна.

Хувцас хадгалах

а. Хувцсыг нарны гэрлийн шууд тусгалаас хамгаалан халаалтын хэрэгслээс 1м, хананаас 0.5м-ын зайд 60%-иас багагүй чийгшилтэй өрөөнд шалнаас 0.2м-ээс багагүй өндөртэй зориулалтын тавиур дээр битүү сав /баглаа боодолд/ хадгална.

б. Хувцсыг органик уусгагчууд, хүчил шүлт болон бусад төрлийн бодисоос тусад нь хадгална.

в. Бохирдсон хувцас, хэрэглэлийг тусгай хүлээн авах өрөөнд бохирдолтын зэрэг болон бохирдсон нөхцөл байдлаар нь ангилан угаалга, хими цэвэрлэгээнд шилжүүлэхэд бэлтгэнэ.

Хувцас, хэрэглэл тээвэрлэх

Хувцсыг ус, чийг, тоосноос хамгаалж, бүрхүүлтэй буюу тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр захиалагч байгууллага руу хүргэж өгнө.

10 Бэлэн хувцсыг хүлээн авах, шалгахад тавих шаардлага

Үйлдвэрлэгч тал:

- а. Үйлдвэрлэгдэх үеийн бохирдлыг цэвэрлэж, утасны үзүүрийг түүсэн байна.
- б. Багц дахь хувцас нэг бүрийг хувцасны нэр төрөл, шинж чанар, материал сонголт, хийц, технологийн шаардлагад тохирч байгаа эсэхийг нягталж шалгасан байна.
- в. Захиалагч байгууллага шаардсан үед үйлдвэрлэсэн хувцасны чанарын үзүүлэлтийг эрх бүхий байгууллагаар тодорхойлуулсан байна.

Захиалагч тал:

- а. Бэлэн болсон хувцсыг энэхүү стандарт болон холбогдох стандартад заасан үзүүлэлт, шаардлага, захиалагчийн баталсан загварын дагуу шалгаж хүлээн авна. Нийлүүлж буй нийт хувцасны 10 хувийг түүвэр судалгаанд сонгон, нарийвчлан шалгана.
- б. Бэлэн бүтээгдэхүүнийг багцаар хүлээн авна. Багц нь дагалдах бичигтэй, үйлдвэрлэгчтэй байгуулсан гэрээнд заагдсан тооны хувцас байна.
- в. Хувцасны өмсгөл хэмжээг багц дахь хувцаснаас түүвэрлэх аргаар сонгож шалгана.
- г. Бүтээгдэхүүний чанарыг манекен (шаардлага хангасан) ашиглаж эсвэл ширээн дээр дэлгэж тавиад нүдээр харж, зориулалтын мэргэжлийн багаж хэрэгслийн тусламжтайгаар шалгана.
- д. Бүтээгдэхүүний ерөнхий хэмжээг туузан метрээр хэмжинэ. Хэрэглэгдэж байгаа туузан метр нь стандартын шаардлага хангасан байх ба механик гажилт болон элэгдэлтэд ороогүй байна.
- е. Хувцас хүлээн авах явцад захиалагч, ханган нийлүүлэгч, үйлдвэрлэгч байгууллагуудын хооронд гарсан маргааныг хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн шийдвэрлэнэ.

ТӨГСӨВ.